



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/657

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “А” дахь заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай, чанар, хүртээмжтэй хүргэхэд үнэтэй хувь нэмэр оруулан нутгийн захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн хөтлөлтийн ажилтан Б.Соёлмаа, Нягтлан бодогч Э.Номин, Мэргэжилтэн Д.Батцацрал, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ө.Хишигтогтох нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан албан хаагчдад 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ